



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА НАРТ

**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

Засгийн газрын VIII байр, Олимпын гудамж 2,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976-51) 26 36 95, Факс: (976-11) 32 35 41
Цахим шуудан: letter@moh.gov.mn
Цахим хуудас: www.moh.gov.mn

2025.03.06 № 2/1126

танай -ны № -т

Чиглэл хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон журмууд хүчингүй болсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллана уу.

1. Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/40 дүгээр тушаал батлагдахаас өмнө тусгай зөвшөөрөл шинээр авах, тусгай зөвшөөрөл сунгуулах, холбогдох өөрчлөлт хийлгэх хүсэлт ирүүлсэн байгууллагын эдгээр үйл ажиллагааг тушаал батлагдахаас өмнө хэрэгжиж байсан журмын хүрээнд богино хугацаанд шийдвэрлэж дуусгах.
2. 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс хойш тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжийн хүсэлтийг Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.12 дахь хэсэгт заасны дагуу Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын албан хаагчдын бүрэлдэхүүнтэй шинжээчийн баг томилж, удирдамжийн дагуу хүсэлтийг хуулийн хугацаанд хянан үзэх.
3. Шинжээчийн багийн гаргасан дүгнэлтийг тусгай зөвшөөрлийн чиг үүрэг хариуцсан нэгж, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд танилцуулж Зөвшөөрлийн тухай хууль болон Эрүүл мэндийн тухай хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллах.
4. Тусгай зөвшөөрлийн сунгалтыг салбарын хяналтын эрсдэлийн үнэлгээ, магадлан итгэмжлэлийн дүгнэлт зэргийг харгалзан Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийг үндэслэн сунгалт хийх.

14/250316